- Автомашины дугаар захиалгын систем www.burtgel.transdep.mn
- Монгол шуудан www.mongolpost.mn
- Хот хоорондын иргэний тээврийн ситем e-ticket.transdep.mn
- Хот хоорондын ачаа тээврийн систем teever.transdep.mn
- Цахилгаан, дулааны техникийн нөхцөл олгох itc.energy.mn зэрэг болно.

Орон нутгийн үйлчилгээний салбарын цахимжилттай холбоотой нийтлэг асуудлууд

1. Нийтийн тээвэр

- Хот хоорондын авто зам ашиглалтын төлбөр уламжлалт аргаар төлдөг;
- Ихэнх аймагт такси дуудлагын цахим систем, үйлчилгээ нэвтрээгүй;
- Нийтийн тээврийн үйлчилгээний систем, зогсоол дээрх хяналтын систем нэвтрээгүй;
- Замын хөдөлгөөний зөрчлийг илрүүлэх, бодит цагийн мэдээллийг хүргэх системүүд цаг үеийн шаардлагаас хоцрогдсон.

2. Аялал жуулчлал

- Зочид буудал, амралтын газар, ресторан, зоогийн газар, үзвэр үйлчилгээний тасалбар захиалга цахимжаагүй;
- Байгалийн болон түүхэн дурсгалт газруудын мэдээллийг цахим хэлбэрт оруулаагүй

3. Амьдрах орчин

- Хог, зам, гудамж талбайн эвдрэл гэмтэл, гэрэлтүүлэг, тоглоомын талбай, нийтийн эзэмшлийн талбайн эвдрэл гэмтэл зэрэг баг, хороодод гардаг зөрчил дутагдлыг шуурхай илрүүлж, мэдээлэлдэг цахим систем нэвтрээгүй;
- Гудамж талбайн ухаалаг гэрэлтүүлгийн системгүй;
- СӨХ-ны үйл ажиллагааны нэгдсэн систем, иргэдэд зориулсан хэрэглээний програм байхгүй;
- Хог хаягдлыг ангилах, ачих, хянах систем нэвтрээгүй;
- Агаарын бохирдлын мэдээллийг бодит цагаар мэдээлэх боломж хомс;
- Гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх хяналтын систем, камержуулалтын байдал хангалтгүй;
- Тусгай хэрэгцээт хүмүүст зориулсан замын хөдөлгөөний гарц, мэдээллийн самбар, зориулалтын апп хомс.

Орон нутгийн үйлчилгээг цахимжуулах зарим шийдлийн санал

Цахим шийдэл нь төрийн үйл ажиллагааг цахимжуулах замаар иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хялбаршуулах, тэдгээрийн хоорондын мэдээллийн урсгалыг сайжруулах, төр, иргэд, аж ахуй нэгжийн цаг хугацааг хэмнэх, зардлыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, хүний хөгжлийг дэмжиж иргэдийн амьдралын хэв маягийг хялбаршуулахад чиглэх ёстой.

1. Авто тээвэр, нийтийн тээврийн салбар

- Аймаг, суманд тээврийн хэрэгслийн нэвтрэлтийн систем суурилуулж хот хоорондын авто зам ашиглалтын төлбөрийг цахимаар хураадаг болох; (ЗТХЯ, орон нутаг)
- Хот хоорондын чиглэлийн ачаа тээвэр, тээврийн хэрэгслүүдэд GPS tracking систем суурилуулах; (ЗТХЯ, орон нутаг)
- Аймаг орон нутгийн гудамжинд зөрчил илрүүлэгч бүхий ухаалаг камер суурилуулах, камерын хяналтын нэгдсэн систем нэвтрүүлэх, камерын ашиглалт, үйлчилгээг сайжруулах; (ЗГ, орон нутаг, ТХХТ)
- Нийслэлд нэвтрүүлсэн Ub Traffic систем шиг аймаг, орон нутгийн замын хөдөлгөөний мэдээллийг иргэдэд бодит цагийн горимд мэдээлдэг систем нэвтрүүлэх; (Орон нутаг, ТХХТ)
- Нийслэлд нэвтрүүлсэн Ub Smart Bus систем шиг аймгийн төвийн сумын автобусны буудлуудад нийтийн тээврийн хөдөлгөөний байршлын ухаалаг хяналтын дэлгэц байршуулах; (Орон нутаг, ТХХТ)
- Жолооч, зорчигчийн аюулгүй байдал, төлбөрийн асуудлыг нэг дор шийдсэн Ub Cab зэрэг такси дуудлагын системийг нэвтрүүлэх. (Орон нутаг, ТХХТ)

2. СӨХ, хог, нийтлэг үйлчилгээ

- Хог ачилт, ангилал, хяналтын нэгдсэн систем нэвтрүүлэх. Иргэд хог хаягдлаа ангилан ялган хаяж сурах, хүн ам их суурьшлын бүсэд хог ачилтын ухаалаг систем нэвтрүүлэх. Энэ нь хогийн цэг дүүрсэн бол хог ачилтын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжийн хяналтын системд автоматаар мэдэгдэл ирдэг цогц систем. Хог ачилтын тээврийн хэрэгслүүдэд GPS төхөөрөмж суурилуулах; (Орон нутаг, ТХХТ)
- Цахилгаан, ус дулаан, хог хаягдал, СӨХ-ийн төлбөр гэх мэт өрхийн хэрэглээний хяналтын системийг нэвтрүүлэх; (Орон нутаг, ТХХТ)
- Орон сууц, гэр хорооллын айлуудын ус, цахилгаан, дулааны тоолуурын мэдээлэл дамжуулах ухаалаг систем нэвтрүүлж гэрээр явж цахилгаан бичихгүй хэрэглэгчийн гар утас, майл хаягаар мэдээлэл ирснээр төлбөрөө төлөх боломж бүрдэнэ. (Орон нутаг, ТХХТ)

3. Аялал жуулчлал, үйлчилгээний салбарын цахимжилт

- Аймаг орон нутагт үйл ажиллагаа явуулдаг зочид буудал, амралт, ресторан, зоогийн газрууд өөрсдийн мэдээллээ оруулан цахимаар захиалга хүлээн авах, байгалийн дурсгалт болон түүхт газруудын мэдээллийг авах боломжтой tapatrip.com, ihotel.mn, touristinfo-center.mn зэрэг системийг нэвтрүүлэх; (Орон нутаг, ТХХТ)
- Орон нутгийн соёл урлаг, үзвэр үйлчилгээний газрын тасалбарыг цахимаар захиалах боломжтой ticket.mn зэрэг системийг орон нутгийн онцлогт тохирсон нэмэлт хөгжүүлэлт хийлгэж нутагшуулах. (Орон нутаг, ТХХТ)

4. Иргэдийн аюулгүй, ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

- Гудамж талбайн гэрэлтүүлгийн шонд хөдөлгөөн мэдрэгч автомат системийг суурилуулах. Энэ нь нарны гэрлийн хавтангаар эрчим хүч цэнэглэгдэж, гэрэлгүй үед хөдөлгөөн мэдрэгчээр ажилладаг эрчим хүчний хэмнэлттэй төхөөрөмж юм; (Орон нутаг, ТХХТ)
- Тусгай хэрэгцээт хүмүүст зориулсан явган хүний гарцын дуут дохио, нийтийн тээврийн чиглэлийн зарлагч мэдээллийн самбарын тоог нэмэгдүүлэх; (Орон нутаг)

- Аймаг, сумын агаарын болон орчны бохирдлын мэдээллийг иргэдэд тогтмол мэдээлэх боломжтой агаарын чанарын ухаалаг хяналтын систем бүхий агаар.mn вэб сайт, гар утасны аппликейшн, гудамжинд байрлах LED дэлгэцийг иргэдийн нягтрал ихтэй газруудад суурилуулах; (Орон нутаг, ТХХТ)
- Үйлчилгээний киоск, өөрөө өөртөө үйлчлэх цахим төхөөрөмж, системүүд (АТМ, e-Map, e-Guide)-уудыг иргэдийн төвлөрөл ихтэй үйлчилгээний цэгүүдэд бий болгох. (Орон нутаг, ТХХТ)

5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх

- Төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэж, ил тод байдлын бий болгох, орон нутгийн удирдлагын үйл ажиллагааг ухаалгаар зохион байгуулах, түргэн шуурхай шийдвэр гаргах боломжийг бүрдүүлсэн нэгдсэн дашбоард нэвтрүүлэх; (Орон нутаг, ТХХТ)
- Аймаг, сумын хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын нэгдсэн удирдлагын систем нэвтрүүлэх; (Орон нутаг, ТХХТ)
- Нийслэлд нэвтрүүлсэн Хэсгийн ахлагчийн систем, гар утасны апп шиг иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг цаг тухай бүрд нь хянаж шийдвэрлэх боломжтой ухаалаг нэгдсэн систем нэвтрүүлэх; (Орон нутаг, ТХХТ)
- Аймгийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбоотой дэд бүтэц, авто зам, инженерийн шугам сүлжээ, нийтийн эзэмшлийн талбайн камер, барилга байгууламжийн бүртгэл зэргийг нэгтгэсэн орон зайн мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх. (Орон нутаг, ТХХТ)

6. Бизнесийн орчныг сайжруулахтай холбоотой цахимжилт

- Аймаг, сумын бүх төрлийн тусгай зөвшөөрөл, лиценз олголтыг цахимжуулж төрийн үйлчилгээний нэгдсэн систем И-Монголтой холбох; (ЦХХХЯ, Орон нутаг, ТХХТ)
- Нийслэлд нэвтрүүлсэн Онлайн бизнес төвийн систем шиг орон нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээнүүдээс хамгийн их хүнд суртал, чирэгдэл үүсгэдэг, иргэд аж ахуйн нэгжээс хамгийн их шүүмжлэл хүлээдэг зөвшөөрөл болон зөвшөөрлийн шинжтэй эрх олгодог үйлчилгээнүүдийг хялбаршуулж, цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх; (Орон нутаг, ТХХТ)
- Иргэд аймагтай холбоотой мэдээ мэдээллийг цаг тухайд нь авах, өөрийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ танилцуулах, зар мэдээ оруулах, ажлын байрны мэдээлэл харах, өргөдөл гомдлоо илгээн шийдвэрлүүлэх, хэрэглээний төлбөрөө нэг дороос төлөх болон өдөр тутам шинэчлэгддэг мэдээ мэдээллүүдийг нэг дороос авах боломж бүхий иргэдэд зориулсан аймгийн гар утасны нэгдсэн аппликейшн нэвтрүүлэх. (Орон нутаг, ТХХТ)

Орон нутгийн эрүүл мэндийн салбарын цахимжилтын нөхцөл байдал

Аймгийн өрхийн болон нэгдсэн эмнэлгүүд health.gov.mn, h.info, e-Health, e-Hospital, kart-e, vhs.mn зэрэг системүүдийг түгээмэл ашиглаж байна.

Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем/e-mongolia.mn/-д 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн системүүд холбогдсон ба эмнэлэгт цаг захиалах, цуцлах, шинжилгээний хариу авах зэрэг үйлчилгээ нэвтэрсэн байна. Гэвч эдгээр үйлчилгээнүүдийг иргэдэд цахимаар үзүүлэхийн тулд тухайн эрүүл мэндийн байгууллага үзлэгийн кабинетууд, боломжит цагууд, өвчтөний шинжилгээний хариуг өөрсдийн ашигладаг эрүүл мэндийн системд бүртгэн оруулсны дараа иргэн e-mongolia.mn-ээр нэвтрэн орж тус үйлчилгээнүүдийг авах боломжтой юм.

Мөн ЭМХТ-ийн дуудлагын төвийн 1800-0119 тусгай дугаараар e-Health программд холбогдсон 47 эмнэлгийн эмчийн үзлэгийн цаг захиалах үйлчилгээ явагдаж байна. 1800-0119 нь энгийн утасны тарифтай буюу ярианы төлбөр 1 минутад 50-70 төгрөгөөр тооцогдох тусгай дугаар юм.

Урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог иргэн өөрийн харьяа өрхийн эрүүл мэндийн төвд хандаж тухайн өрхийн эрүүл мэндийн төв нь аймаг, сумдын хэмжээнд эрт илрүүлгийн үзлэг оношилгоо хийх бололцоотой тоног төхөөрөмж, хүчин чадал бүхий хувийн болон улсын эрүүл мэндийн байгууллагууд руу хуваарилан илгээх зарчмаар явагдаж байна. Иймд иргэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг оношилгоонд хамрагдахдаа аль нэг эмнэлэгт цаг авч бүртгүүлэх боломжгүй байна.

Аймгийн удирдлага аймгийн хэмжээнд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн тоон мэдээлэл, өвчлөлийн статистик болон бусад мэдээллийг харах эрх хязгаарлагдмал байна.

Эрүүл мэндийн яам 2007 оноос алслагдсан орон нутаг, сумын эрүүл мэндийн салбарын үйлчилгээг сайжруулах зорилгоор орон даяар Телемедициний үйлчилгээг нэвтрүүлсэн. Телемедицин нь шууд видео холболт хийж зөвлөгөө авах /realtime/, програм хангамж ашиглан зөвлөгөө авах (store and forward) гэсэн 2 чиглэлээр үйлчилгээг авах боломж бүрдсэн боловч орон нутагт эдгээрийн ашиглалт хангалтгүй байна.

Орон нутгийн эмнэлгүүдэд тохиолддог нийтлэг хүндрэл, бэрхшээлүүд

- Эрүүл мэндийн газар, өрхийн болон аймгийн нэгдсэн эмнэлэгт одоо ашиглаж байгаа цаг авах, үзлэгийн бүртгэл, эмчилгээ, тайлан бүртгэлийн олон системүүд нь хоорондоо уялдаагүйгээс эмч, ажилтнуудад хүндрэл учруулдаг, оочер дараалал үүсгэж, иргэдийн бүхимдал төрүүлдэг.
- Өрхийн эмнэлэгт үзлэгийн мэдээллийг ЭМЯ, ЭМХТ, ЭМДЕГ-т зориулан өөр өөр системд тус тусад нь шивж оруулахад өвчтөн үзэхээс 2-3 дахин их цагийг мэдээллийн зарцуулдаг, эмч ажилтнууд илүү цагаар ажиллах шаардлага үүсдэг.
- Иргэд үзлэгт орох, шинжилгээ өгөх, шинжилгээний хариу авах, эмчтэйгээ харилцахдаа заавал биечлэн очих шаардлагатай болдог, цахимаар цаг авах боломж хомс.
- Иргэн аль ч шатлалын эмнэлэгт очсон өмнө хийгдсэн эмчилгээ, өвчний түүхээ цаасан хэлбэрээр авч явдаг, нэгдсэн байдлаар цахимаар харах, ашиглах боломж байхгүй.
- Эмийн жорын цахим бүртгэлийн систем нэвтрээгүйгээс эмийн сангууд эмчийн бичиж өгсөн цаасан жороор үйлчилдэг хэвээр байна.

Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагуудын цахимжилтын зорилго, хэрэгжүүлэх арга хэмжээ

Эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай, хүнд сурталгүй, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран чанартай хүргэдэг болохын тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай.

1. *Анхан болон лавлагаа шатны эмнэлгийн үзлэгийн цаг захилга, шинжилгээний хариу авах, эмийн жор олголт зэргийг цахимжуулах*
 - Анхан шатны эмнэлгүүдэд одоо ашиглаж буй өөр өөр системүүдийг нэгтгэх, интеграци холболт хийх, дуудлагын төвүүдийн системд холбох замаар иргэдэд цахимаар цаг захиалах боломжийг бүрдүүлэх, эмч, ажилтны ачааллыг бүүруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах. (ЭМЯ)
 - Одоогоор холбогдсон байгаа аймгийн эрүүл мэндийн төвүүд нь үзлэгийн боломжит бүх кабинетууд, боломжит цагууд, өвчтөний шинжилгээний хариуг e-mongolia.mn системд бүртгэн оруулдаг болох. (Анхан болон лавлагаа шатны эмнэлгүүд)

- Аймаг, сумын өрхийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэгт цаг захиалах, шинжилгээний хариу авах, эмийн жор хэвлэн авах, эмчийн магадалгааны лавлагаа авах, 13В маягтын лавлагаа авах, вакцины гэрчилгээ авах, эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах боломж бүхий киоск машиныг суурилуулах. (ЦХХХЯ, орон нутаг)

2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдагсдын хяналтын цахим систем нэвтрүүлэх

- Аймгийн хэмжээнд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн тоон мэдээллийг, өвчлөл тус бүрээр нь ангилан харуулах эрүүл мэндийн нэгдсэн дашбоард хөгжүүлж хяналт тавих. (ЭМЯ, орон нутаг)
- Эрт илрүүлэгт хамрагдсан иргэдээс дахин оношилгоо, эмчилгээ хийлгэх шаардлагатай иргэдийг эргэн дуудах, дахин оношилгоонд хамрагдсан эсэх талаар төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ийг ашигладаг болох. (ЭМЯ, орон нутаг)

3. Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний цахим системүүдийг нэвтрүүлэх

- Мобайл технологид суурилсан гэрийн хяналтын телемедициний үйлчилгээг нэвтрүүлэх, үзлэгийн хамрах хүрээ, чиглэлийг нэмэгдүүлэх, тэдгээрт үндэслэсэн дүрэм, журмыг гаргаж мөрдүүлэх. (ЭМЯ)
- Телемедицины программ, техник хангамжийг сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд суурилуулахын тулд эмнэлгийн интернэтийн хурдыг 8 МВps болон түүнээс дээш хүртэл нэмэгдүүлэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх. (ЭМЯ, орон нутаг)

4. Эмийн жор олголтыг цахимжуулах, эмнэлэг, эмийн сангуудын байршлыг цахимаар мэдээлдэг болох

- Нийслэлд туршаад буй эмийн жорын бүртгэлийн систем “E-JOR” системийг орон нутагт нэвтрүүлэх. Улмаар уг системийг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд холбосноор иргэд эмчээс бичиж олгосон “Энгийн эмийн жорын маягт”-ыг иргэд хэвлүүлж авах шаардлагагүйгээр “e-mongolia.mn” системд нэвтрэн орж өөрийн болон өөрийн нэр дээр бүртгэлтэй хүүхдийн нэр дээр бичигдсэн маягтыг харах, эмээ авах боломж бүрдэнэ. (ЭМЯ)
- Аймаг, сумын ЗДТГ-ын цахим хуудсанд аймаг, сум, хороо, багийн газрын зургийг байршуулж, эрүүл мэндийн байгууллага, эм, эмнэлгийн газрууд болон эмийн сангуудын байршлыг тусгай тэмдэглэгээгээр ялган харуулах хөгжүүлэлтийг хийх. (Орон нутаг)

5. Бусад

- Аймаг сумдын хүн амын өвчлөл, тархац, мэдээллийг эрүүл мэндийн салбарын статистик мэдээллийн системүүдтэй интеграци хийж өөрсдийн цахим хуудсанд байршуулах. (Орон нутаг)
- Аймаг, сумын өрхийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүдэд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, аудит хийлгэх. (ЦХХХЯ, орон нутаг)
- Эмнэлгийн мэдээллийн технологийн мэргэжилтнийг чадавхжуулах. (ЭМЯ, орон нутаг)
- Аймгийн удирдлага аймгийн хэмжээнд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн тоон мэдээлэл, өвчлөлийн статистик болон бусад мэдээллийг бодит цагийн горимд \real-time\ харах боломжтой дашбоардтай болох. (Орон нутаг)

Орон нутгийн боловсролын салбарын цахимжилтийн нөхцөл байдал

2018 онд байгуулагдсан Боловсролын мэдээллийн технологийн төв нь боловсролын салбарт удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлж, тогтвортой хөгжүүлснээр цахим засаглал, инновацыг ашиглаж боловсролын үйлчилгээг цахимжуулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Боловсролын салбарын **esis.edu.mn** систем нь мэдээллийн систем, сургалтын цахим контент, удирдлагын систем, мэдээллийн санг цогцоор нь шийдсэн үндсэн систем юм. Мөн эцэг эх, багш болон сурагчдад зориулсан сургууль, цэцэрлэгийн хүрээнд болж буй мэдээлэл, хяналтын платформ, багшийн оруулсан өдөр тутмын ирц, дүн үнэлгээ зэрэг мэдээллүүдийг оруулснаар эцэг эхчүүд хүүхдийнхээ сургууль дээр болж буй мэдээллийг цаг алдалгүй авах боломжтой байдаг.

Орон нутгийн сургалтын байгууллагуудад дараах дэд системүүдийг ашиглаж байна. Үүнд:

1. Багшийн мэдээллийн систем bagsh.esis.edu.mn
Багшийн мэдээлэл, суралцагч, багшийн журнал, ангийн журнал, сэдвийн сан, эцэг эх холбох хүсэлт, хичээлийн хуваарь, гарын авлага, үдийн хоолны мэдээллийг харах, бүртгэл хөтлөх боломжтой систем.
2. Цахим контентын систем /Сурах бичиг, Теле, Интерактив хичээл/ medle.mn
Тус системийг ашиглан нийслэл, орон нутаг, алслагдсан бүсээс цахимаар нэвтэрч сургуулийн өмнөх боловсрол, ерөнхийн боловсрол, тусгай хэрэгцээт боловсрол, насан туршийн боловсрол гэр бүлийн боловсрол, цахим боловсрол гэсэн ангилалтайгаар сурах бичиг, теле хичээл, нэмэлт контентуудыг ашиглах боломжтой.
3. Эцэг, эхийн систем parent.edu.mn
Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ сурлагын амжилт, хичээлийн хуваарь, хичээлийн ирц, улирлын болон шалгалтын дүн үнэлгээ, гэрийн даалгавар, сургалтын байгууллагын талаарх мэдээллийг харах, хянах боломжоор хангахад зориулагдсан систем.
4. Сургалтын тэтгэлгийн систем scholarship.esis.edu.mn
Засгийн газар хоорондын гэрээгээр батлагдсан хөтөлбөрүүд, тэтгэлэгтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хүлээн авах, өргөдөл бичих, тэтгэлэгт хамрагдах систем.
5. Боловсролын салбарт хэрэгжиж буй төслүүдийн явцын газарзүйн мэдээллийн систем gis.edu.mn.
6. Цэцэрлэг, сургуулийн тусгай зөвшөөрлийн систем license.edu.mn.
7. Цахим төсвийн систем fin.esis.edu.mn.

Орон нутгийн боловсролын байгууллагуудын цахимжилтад тулгамдаж буй нийтлэг хүндрэл, бэрхшээлүүд

- Аймаг, сумдын сургууль, цэцэрлэгийн хичээлийн танхим, дотуур байрны дотоод сүлжээ, тоног төхөөрөмж хуучирсан, интернэт холболт хангалтгүй;
- Сургууль сүлжээнд холбогдсон боловч сургалтын зорилгоор ашиглахад интернэтийн хурд, хүчин чадал хангалтгүй байдаг;
- Сургууль, цэцэрлэгийн багш, мэргэжилтнүүдийн интернэтийн хэрэглээний төсөв хүрэлцдэггүй;

- Сургалтын ухаалаг тоног төхөөрөмж, ухаалаг самбар, багшийн зөөврийн компьютер, таблет хангалтгүй, хуучирсан;
- Багшийн цахим журнал, сурагчийн цахим хувийн хэргийн системийг ашиглалт хангалтгүй;
- Багш нарын цахим контент бэлтгэх, сургалтад ашиглах, цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт цөөн хийгддэг;
- Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан хүүхдийн аюулгүй байдал, үдийн хоолыг хянах цахим систем нэвтрээгүй;
- Ахлах сургуулийн сурагч, оюутнуудад зориулсан гадаад, дотоодын тэтгэлэгт хөтөлбөрийн тухай мэдээлэл, зар хүрдэггүй;
- Аймгийн удирдлага аймгийн хэмжээнд боловсролын салбарын нэгдсэн мэдээлэл, шалгалтын дүн зэргийг нэгдсэн байдлаар харах дашбоард байхгүй, сургуулиудын үйл ажиллагаа, сургалтын үзүүлэлт, чанарыг бодит цагийн горимд хянах боломжгүй
- Цэцэрлэгт хүүхэд элсүүлэх бүртгэлийн цахим систем нэвтрээгүй;
- Насан туршийн боловсролын сургалтад цахим контент, хөтөлбөр цөөн нэвтэрсэн;
- Аймаг, сумдын ЕБС-иудад нарийн мэргэжлийн багш дутагдалтай, бүлэг бүрддэггүй зэргээс болж ахлах ангийн хүүхдүүд өөрийн сонгосон “Сонгон суралцах хөтөлбөр”-т хамрагдаж чадахгүй байдал түгээмэл. Үүнээс болж математик, байгалийн ухаан, инженер, технологийн нарийн мэргэжлээр дараагийн шатны сургуульд суралцах авъяас, сонирхолтой хүүхдүүдийн эрх ашиг хохирох, улмаар хөдөлмөрийн зах зээлд эдгээр мэргэжилтнүүдийн хомсдолд хүрэх тохиолдол гардаг.

Аймаг, сумын боловсролын байгууллагуудын цахимжилтын зорилго, хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Сургууль, цэцэрлэгийн харилцаа холбооны дэд бүтэц, интернэтийн хүртээмжийг сайжруулах

- БШУЯ-наас хэрэгжүүлж буй “УБС, МСҮТ-ийн хичээлийн байр, дотуур байранд дотоод сүлжээ байгуулах” төсөлд аймаг, сумдын сургуулиудыг бүрэн хамруулах. Ингэснээр сургууль орчмын бүсийн интернэт хүртээмж нэмэгдэж, өндөр хурдны интернэтийг ашиглах боломжтой бүрдэнэ. (БШУЯ, орон нутаг)
- БШУЯ-наас ЕБС-уудад хуваарилсан Цахим хэрэглээний зардал, Тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлын хүрээнд сургуулийн хэвийн үйл ажиллагааг хангахуйц интернэтийн үрсгал, зөөврийн компьютер, ухаалаг тоног төхөөрөмжийн худалдан авалтыг тухай бүр зохион байгуулах, “ухаалаг анги” байгуулах. (БШУЯ, ЕБС, МСҮТ)

2. Сургалтын систем, программ хангамжийг хэрэглээ, ашиглалтыг сайжруулах

- Аймаг, сумдад Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-тэй холбогдсон цэцэрлэгийн цахим бүртгэлийн системийг нэвтрүүлэх. (БШУЯ, Орон нутаг)
- Бага ангийн хүүхдэд зориулсан Eduten математикийн хичээлийн палформ, дунд ангийн сурагчдад зориулсан Pearson англи хэлний хөтөлбөр, анхлах ангийн хүүхдэд зориулсан medle.mn сонгон судлах хичээлийн платформыг бүрэн ашиглаж хэвших. (БШУЯ, ЕБС, МСҮТ)

3. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эцэг эхийн хяналтыг сайжруулах

- Эцэг эх, хүүхдүүдэд e-mongolia системийн ekids цэсийг ашиглах сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, эцэг эхийн хяналтыг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах. (ЕБС, эцэг эх)
- Хүүхдийн үдийн хоолыг хянах цахим систем нэвтрүүлэх. (ЕБС, цэцэрлэгүүд)

4. Бусад

- scholarship.esis.edu.mn системийг аймаг, сумын ЗДТГ-ын цахим хуудастай холбох, мэдээллийг эх эцэг, сурагчдад сурталчлах. Боловсролын гадаад болон дотоодын тэтгэлгийн боловсролын чиглэлээр scholarship.esis.edu.mn системийг ашиглан Засгийн газар хоорондын гэрээгээр батлагдсан хөтөлбөрүүд, тэтгэлэгтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хүлээн авах ба тус системд нэвтрэх эрх нээн зарлагдаж буй хөтөлбөр, тэтгэлэгт цахимаар өргөдөл илгээн хамрагдах боломжтой. (Орон нутаг, ЕБС)
- Аймаг дах Албан бус боловсролын төв болон И-Монгол академи, ТЦҮЗГ хамтран иргэдийн цахим үр чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, орон нутгийн иргэдийн насан туршийн боловсролд хамрагдах хүсэлтийг цахимаар хүлээн авдаг систем нэвтрүүлэх. (ЦХХХЯ, БШУЯ, орон нутаг)
- ЕБС-ийн удирдлагуудыг МХХТ-ийн манлайлалд сургах, сургуулийнхаа МХХТ-ийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг болох арга хэмжээг зохион байгуулах. (БШУЯ, орон нутаг)
- Багш байхгүй, анги бүрдээгүй зэрэг шалтгаанаас болж ахлах ангийн “Сонгон суралцах хөтөлбөр”-ийн байгалийн ухааны гүнзгийрүүлсэн хичээлүүд, мэдээллийн технологи, дизайн зэрэг 16 хичээлээр суралцах сонирхолтой хүүхдүүдийг БШУЯ-ны дэргэд байгуулагдсан цахим сургуульд хамруулан сургах ажлыг зохион байгуулах. (БШУЯ, Орон нутаг, ЕБС)

АЙМГУУДЫН ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН СУДАЛГААНЫ АСУУЛГА

- 1.1. Аймаг, орон нутгийн Цахим шилжилтийг эрчимжүүлэх төлөвлөгөөг батлуулсан эсэх?
- 1.2. Салбар хоорондын цахимжуулалт болон оролцогч талуудын уялдаа холбоог хангах талаар арга хэмжээ хэрэгжүүлж байгаа эсэх?
- 1.3. Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлэх, харилцаа холбооны үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд нэгдсэн төлөвлөлттэй хүргэх талаар арга хэмжээ хэрэгжүүлж байгаа эсэх?
- 1.4. Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг түргэн, шуурхай байгуулах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд дараах ажлуудаас хэрэгжүүлж байгаа ажлыг сонгоно уу?
 - 1.4.1. Аймаг, орон нутгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төслийг холбогдох бүх дэд бүтцийн салбаруудын уялдаа холбоог хангаж, нэгдсэн байдлаар төлөвлөсөн;
 - 1.4.2. Аймаг, орон нутгийн барилга хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөний төслийг холбогдох бүх дэд бүтцийн салбаруудын уялдаа холбоог хангаж, нэгдсэн байдлаар төлөвлөсөн;
 - 1.4.3. Хот байгуулалтын болон бусад үйл ажиллагаатай холбоотой газар олгохдоо харилцаа холбооны шугам, сүлжээний даац, боломжийг урьдчилан санал авч тодруулан олгодог;
 - 1.4.4. Аймгийн хөгжлийн төсөл, хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулахдаа Эрчим хүч, цэвэр, бохир усны болон зам, замын байгууламж, тээврийн байгууламж зэрэг инженерийн дэд бүтцийг харилцаа холбооны шугам, сүлжээ, тэдгээрийн дэд бүтэцтэй хамтад нь төлөвлөн, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс санал авдаг;
 - 1.4.5. Хот, суурин газар, дүүрэг, хорооллын чанартай инженерийн бэлтгэл арга хэмжээ, шинэ хороолол, бичил хорооллыг санаачлан төлөвлөхдөө харилцаа холбооны шугам, сүлжээ, тэдгээрийн дэд бүтцийг бусад инженерийн дэд бүтэцтэй хамтад нь төлөвлөн, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс санал авдаг;
 - 1.4.6. Өөрийн нутаг дэвсгэрт байгаа харилцаа холбооны сүлжээ, түүний хамгаалалтын зурвас газрын талаар тооллого, судалгааг явуулж, газрын нэгдсэн санд бүртгэгдээгүй харилцаа холбооны хамгаалалтын зурвас газруудыг нөхөж бүртгэдэг;
 - 1.4.7. Барилгын дотор болон гадна мэдээлэл холбооны шугам, сүлжээ, худаг сувагчлалыг холбогдох норм, стандартын дагуу зураг төсөлд тусгуулж, гүйцэтгэлд зураг төслийн дагуу баригдаж байгаа эсэхэд хяналт тавьж, ашиглалтад хүлээж авах норм, нормативыг хэрэгжүүлж ажилладаг;
 - 1.4.8. Төлөвлөлтөд шаардагдах дэд бүтцийн техникийн нөхцлийг харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигчээс авдаг;
 - 1.4.9. Харилцаа холбооны шугам, сүлжээ, тэдгээрийн дэд бүтцийг төлөвлөөгүй эрчим хүч, цэвэр, бохир усны болон зам, замын байгууламж, тээврийн байгууламжийн техникийн нөхцөлийн зөвшөөрөл, бүрдлийг хангаагүйд тооцдог;
 - 1.4.10. Харилцаа холбооны шугам, сүлжээ байрлаж буй газрыг солих, эргүүлэн авахдаа зардлыг бүрэн судалж, төсөвт суулгадаг.

- 1.5. Эрүүл мэндийн салбарт цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээг тодорхойлно уу:
 - 1.5.1. Анхан шатны үзлэгийн цаг цахимаар захиалах;
 - 1.5.2. Урьдчилан сэргийлэх үзлэгийн цаг цахимаар захиалах;
 - 1.5.3. Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг цахимаар авах;
 - 1.5.4. Эмийн жор олголт цахим хэлбэрт шилжсэн;
 - 1.5.5. Эмийн сангуудын байршлын талаар мэдээллийг цахимаар авах;
 - 1.5.6. Эмнэлэг хооронд өгөгдөл, мэдээллийг нэгдсэн системээр солилцох;
 - 1.5.7. Шинжилгээний хариу цахимаар авах;
 - 1.5.8. Аймгийн нэгдсэн эмнэлэг нь мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ, аудит хийлгэсэн.
- 1.6. Боловсролын салбарт цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээг тодорхойлно уу:
 - 1.6.1. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах бүртгэлийг цахимаар хийх;
 - 1.6.2. Сүүрх боловсролд хамрагдах бүртгэлийг цахимаар хийх;
 - 1.6.3. Насан туршийн боловсролд хамрагдах бүртгэлийг цахимаар хийх;
 - 1.6.4. Цахим сургуулийн платформ ашиглах;
 - 1.6.5. Эцэг эх, асран хамгаалагчийн системийг ашиглах;
 - 1.6.6. Тусгай зөвшөөрөл олгох зорилго бүхий системийг ашиглах;
 - 1.6.7. Тэтгэлэгтэй холбоотой мэдээлэл авах зорилго бүхий системийг ашиглах;
 - 1.6.8. Сургуулиудад цахим сургалтын орчин бүрдүүлсэн.
- 1.7. Зам тээврийн салбарт цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээг тодорхойлно уу:
 - 1.7.1. Авто замын торгуулийн систем ашиглах;
 - 1.7.2. Авто зам ашиглалтын төлбөрийн мэдээлэл харуулах, төлбөр хураах систем ашиглах;
 - 1.7.3. Улс, хот хоорондын автобусны тасалбар борлуулалтын систем ашиглах;
 - 1.7.4. Дотоодын ачаа тээврийн систем ашиглах;
 - 1.7.5. Замын хөдөлгөөний бодит цагийн мэдээллийг хүртээмжтэй хүргэх систем ашиглах.
- 1.8. Эрчим хүч/Дулааны салбарт цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээг тодорхойлно уу:
 - 1.8.1. Цахилгаан эрчим хүчний зарцуулалтыг хянах систем ашиглах;
 - 1.8.2. Төлбөр тооцооны систем ашиглах;
 - 1.8.3. Түгээх сүлжээнд шинээр холбогдох иргэн, ААН-ийн хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, мэдээллээр хангах систем ашиглах;
 - 1.8.4. Эрчим хүчний нөөцийн хяналтын систем ашиглах.
- 1.9. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээг тодорхойлно уу:
 - 1.9.1. Аймаг, нийслэлийн газрын зургийг цахим хэлбэрт шилжүүлэх;
 - 1.9.2. Захиалгын үйлчилгээг цахимаар авах;
 - 1.9.3. Ресторан, зоогийн газар захиалгын үйлчилгээг цахимаар авах;
 - 1.9.4. Соёл урлаг/ үзвэр захиалгын үйлчилгээг цахимаар авах;
 - 1.9.5. Амралтын газар захиалгын үйлчилгээг цахимаар авах;
 - 1.9.6. Байгалийн дурсгалт газрын талаарх мэдээллийг цахимжуулах;
 - 1.9.7. Түүхийн дурсгалт газрыг бүртгэлийн системд байршуулах;

- 1.9.8. Аялал жүүлчлалын салбарын бизнес эрхлэгчдийн мэдээллийг нэг санд нэгтгэх;
- 1.9.9. Байгаль хамгааллын систем ашиглах;
- 1.9.10. Ан амьтан хамгаалал/ тоо бүртгэлийн систем ашиглах;
- 1.9.11. Агаарын бохирдлын систем ашиглах
- 1.9.12. egazag.gov.mn тушаал шийдвэрийн мэдээллийг бүрэн оруулдаг.

10. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээг тодорхойлно уу:

- 1.10.1. Мал тооллогын бүртгэлийн систем ашиглах;
- 1.10.2. Газар тариалангийн хяналтын систем ашиглах;
- 1.10.3. Бэлчээрийн хяналтын систем ашиглах;
- 1.10.4. Цэвэр усны нөөцийн хяналтын систем ашиглах;
- 1.10.5. Байгалийн баялгийн нөөцийн хяналтын систем ашиглах.

11. Цахим аймаг, нийслэлийг бүрдүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тодорхойлно уу:

- 1.11.1. Хог хаягдлыг ангилах, ачих, хянах систем ашиглах;
- 1.11.2. Талбайн гэрэлтүүлгийн систем ашиглах;
- 1.11.3. Газар зүйн мэдээллийн систем ашиглах;
- 1.11.4. СӨХ-ийн үйл ажиллагааны нэгдсэн систем ашиглах;
- 1.11.5. Байгалийн гамшгийг урьдчилан мэдээлэх систем ашиглах;
- 1.11.6. Гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх Теле хяналтын систем ашиглах;
- 1.11.7. Хотын цэвэр усны эх үүсвэрийг хянах систем ашиглах;
- 1.11.8. Бохир усны удирдлагын систем ашиглах;
- 1.11.9. Усны ухаалаг тоолуур ашиглах;
- 1.11.10. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем ашиглах;
- 1.11.11. Гэр бүл, хүүхэд хамгааллын систем ашиглах;
- 1.11.12. Тусгай зөвшөөрлийн нэгдсэн санд мэдээлэл нийлүүлдэг.

- 2.1. Аймаг, орон нутгийн Засаг даргын Тамгын газар нь мэдээллийн аюулгүй байдлын журам баталсан эсэх?
- 2.2. Аймаг, орон нутгийн Засаг даргын Тамгын газар нь Цахим орчинд хүүхэд хамгаалах бодлоготой эсэх?
- 2.3. Иргэдэд зориулсан ямар нэгэн цахим мэдээллийн хэрэгсэл ашигладаг уу?
- 2.4. Иргэдтэй харилцдаг цахим хуудас, портал нь хүртээмжийн стандарт баримталдаг эсэх? (WCAG 2.0)
- 2.5. Цахим хэлбэрээр үзүүлж байгаа төрийн үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хүргэж, сурталчлах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо?
- 2.6. Төрийн албан хаагчдад тоон бичиг үсгийн үр чадвар олгох чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо?
- 2.7. Системүүд нь үндсэн болон дэмжих системд холбогдох боломжтой байдлаар хөгжүүлэгдсэн эсэх?
- 2.8. Системүүд нь бусад системүүдтэй мэдээлэл солилцдог эсэх?
- 2.9. Нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг нэгтгэн харах боломж бүхий дашбоардтай эсэх?

- 2.10. Нээлттэй мэдээллээ Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу нийтэлж байгаа эсэх?
- 2.11. Тухайн жил цахимжуулсан төрийн үйлчилгээний тоо, хувиар?
- 2.12. Иргэнд нэн тэргүүнд шаардлагатай үйлчилгээг цахимжуулсан эсэх? Газар, Барилга, Байгаль орчин, Бизнес эрхлэх зэрэгтэй холбоотой зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулсан эсэх; аягийн бүртгэл, Газар өмчлөх, зэмших, ашиглах эрхийн бүртгэл, Тээврийн хэрэгслийн бүртгэл зэрэгтэй холбоотой үйл ажиллагааг цахимжуулсан эсэх; Усны төлбөр, цахилгааны төлбөр гэх мэт)
- 2.13. Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын явцыг мэдээлж, асуудал шийдвэрлэхэд иргэдээс санал авах нөхцлийг цахим хэлбэрээр бүрдүүлсэн эсэх?
- 2.14. Иргэдийн санал, гомдол, зөрчлийг хүлээн авах, эргэн хариу өгөх процессыг цахим хэлбэрт шилжүүлсэн эсэх?
- 2.15. Кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээлэл холбооны сүлжээний болон түүний зурвас газарт давхардуулан газар эзэмшүүлэх шийдвэр гаргахгүй байх чиглэлээр өөрийн бүрэн эрхийн хүрээнд захирамж гаргадаг эсэх?
- 2.16. Аймаг, орон нутгийн газрын албанд харилцаа холбооны зурвас газрыг бүртгэхэд үүсч буй хүндрэлийг арилгах талаар арга хэмжээ хэрэгжүүлдэг эсэх?
- 2.17. Харилцаа холбооны хамгаалалтын зурвас газрыг олгоход бусад инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас газартай давхардсан тохиолдолд тухайн газрыг харилцан нөлөөлөл үзүүлэхгүйгээр хамтран ашиглах нөхцөлийг бүрдүүлэх талаар арга хэмжээ хэрэгжүүлдэг эсэх?
- 2.18. Аймгийн төвийн өндөр хурдны өргөн зурвасын сүлжээний холболт?
- 2.19. Өргөн зурвасын интернэтэд холбогдсон өрхийн нэвтрэлтийн түвшин?
- 2.20. Иргэд хамгийн их цуглардаг газруудаар утасгүй хандалтын цэг (WiFi) нэвтрүүлсэн эсэх?
- 2.21. Харилцаа холбоо, мэдээллийн технологид суурилан байгалийн гамшгийг урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулдаг эсэх?
- 2.22. Иргэдийн компьютер эсвэл бусад ухаалаг төхөөрөмжийн хэрэглээний түвшин хангалттай эсэх?
- 2.23. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан операторын горимоор үйлчилгээ үзүүлсэн үйлчилгээний тоо?
- 2.24. Аймаг, орон нутгийн үйл ажиллагаанд шинэ технологийг нэвтрүүлэх талаар арга хэмжээ хэрэгжүүлж байгаа эсэх? (жишээ нь: Хиймэл оюун ухаан, IoT, блокчейн, Ухаалаг хот, 5G, VR/AR, робот техник, 3D хэвлэх)
- 2.25. Аймаг, орон нутгийн удирдлагууд шийдвэр гаргах үйл явцад их өгөгдлийг ашигладаг эсэх?
- 2.26. Аймаг, орон нутгаас үзүүлж байгаа үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрэлтийн түвшин?
- 2.27. Аймаг, орон нутаг нь Цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр төсөв хуваарилсан эсэх?
- 2.28. Цахим шилжилттэй холбоотой төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэхдээ суурь судалгаа хийж системийн давхардал үүсэхээс сэргийлдэг эсэх?
- 2.29. Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-д багтсан өгөгдлийг заасан хугацаанд нийтэлдэг эсэх?
- 3.1. Бүх нийт (хөгжлийн бэрхшээлтэй иргэд, амьдралын түвшин доогуур иргэд, гэртээ байгаа

- эмэгтэйчүүд, хүүхэд гэх мэт)-ийг Төрийн шийдвэр гаргалтад цахимаар тэгш, хүртээмжтэй хамруулах талаар арга хэмжээ хэрэгжүүлдэг эсэх?
- 3.2. Зорилтот бүлгийн иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар, хүртээмжтэй хүргэх талаар арга хэмжээ хэрэгжүүлсэн эсэх?
 - 3.3. Зорилтот бүлгийн иргэдэд зориулан тусгай цахим үйлчилгээ үзүүлдэг үү?
 - 3.4. Зорилтот бүлгийн иргэдэд тоон бичиг үсгийн үр чадвар олгох талаар арга хэмжээг зохион байгуулдаг уу?
 - 3.5. Албан ёсны цахим хуудсанд төрийн үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааг иргэд, аж ахуйн нэгжээс авдаг эсэх?
 - 3.6. Иргэдийн цахим оролцооны талаар дүгнэлт, тайлан гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнд тусган ажилладаг эсэх?
 - 3.7. Иргэдийн цахим үр чадварын түвшинг хэмждэг эсэх?
 - 3.8. Иргэдийн цахим үр чадварыг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулдаг эсэх?
- 4.1. Аймаг, орон нутгийн байгууллагуудыг албан бичиг солилцооны дундын системд холбосон байдал?
 - 4.2. Нийт албан бичгээс цахимаар илгээж, хүлээн авсан албан бичгийн хувь?
 - 4.3. Цахим албан хэрэг хөтөлөлтийн буюу дотоод удирдлагын систем ашиглалтын байдал?
 - 4.4. Аймаг, орон нутгийн байгууллагуудын дотоод системийг ашиглан нийт албан хаагчдад мэдээ, мэдээлэл хүргэсэн байдал?
 - 4.5. Цахим шилжилт хариуцсан албан хаагчтай эсэх?
 - 4.6. Мэдээллийн технологийн ажилчдыг мэргэшүүлэх чиглэлээр сургалтад хамруулсан тоо?
 - 4.7. Тоон гарын үсэг олгосон иргэдийн тоо?
 - 4.8. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд тоон гарын үсгийг нэвтрүүлсэн эсэх (албан бичиг боловсруулалт, шилжүүлэх, өргөдөл гомдлын хариу г.м)
- 5.1. Үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлжэн төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монголиа системд холбосон байдал?
 - 5.2. Төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монголиа системээр үзүүлсэн үйлчилгээний хувь?
 - 5.3. Төрийн цахим үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааг үндэслэн хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо?
 - 5.4. Тухайн жил цахим хэлбэрээр төрийн үйлчилгээг авсан иргэдийн тоо?
 - 5.5. Иргэдийн цахим үйлчилгээний хамрагдалтыг хэмждэг эсэх?
- 6.1. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн төсөл, хөтөлбөрт хөрөнгө оруулалт төсөвлөдөг эсэх?
 - 6.2. Аж ахуй нэгж, бизнес эрхлэгчдийг нэгтгэсэн системтэй эсэх?
 - 6.3. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын судалгаа шинжилгээний төвтэй эсэх?
 - 6.4. Гарааны бизнес эрхлэгчдийг мэдээллийн технологийн тусламжтайгаар дэмжих бодлоготой эсэх?
 - 6.5. Аж ахуй нэгж, бизнес эрхлэгчдэд чиглэсэн үйлчилгээг цахимжуулсан эсэх?

21 АЙМГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАД НИЙТЛЭГ АШИГЛАГДАЖ БАЙГАА СИСТЕМҮҮД

№	Байгууллага	Ашиглаж байгаа системүүд	Системийн тайлбар
1	АЗДТГ	Able, erp.e-mongolia.mn	Цахим албан хэрэг хөтлөлтийн систем
2		new.unelgee.gov.mn	Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний систем
3		e-report.mof.gov.mn/EReport	Төрийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн цахим нэгтгэлийн систем
4		odamis.mof.gov.mn/login	Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем
5		shilendans.gov.mn	Шилэн данс
6		Finance.gov.mn	Төрийн сангийн удирдлагын цахим систем
7		pimis.publicinvestment.gov.mn	Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем
8		ereporting.eitimongolia.mn	ОУИТБС-ын Цахим тайлагналын систем
9		sudalгаа.gov.mn	Үндэсний судалгааны нэгдсэн платформ
10		Etax.mta.mn	Цахим санхүүгийн тайлангийн систем
11		Nd8.ndaatgal.mn	Нийгмийн даатгалын тайлангийн систем
12		Payroll.gov.mn	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем
13		E-report.mof.gov.mn	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем
14		Ebalance.mof.gov.mn	Цахим санхүүгийн тайлангийн систем
15		e-document.gov.mn	Архивын систем
16	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Able, erp.e-mongolia.mn	Цахим албан хэрэг хөтлөлтийн систем
17	Биеийн тамир, спортын газар	hrm.csc.gov.mn/hrsuite	Төрийн албаны цахим систем
18		sport.dynamic.mn	Санхүү бүртгэлийн систем
19		cpanel.sport.gov.mn	Тамирчдын мэдүүлэг илгээх систем
20	Боловсрол, шинжлэх ухааны газар	esis.edu.mn	Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, сурагч ажилчдын дата мэдээ.
21		hrm.csc.gov.mn	Хүний нөөцийн систем
22		auth.itc.gov.mn	Цалингийн систем
23		bi.esis.edu.mn	Байгууллагын болон багшийн үнэлгээний дата боловсруулах
24		stat.eec.mn	Байгууллагын болон багшийн үнэлгээний үр дүн харах
25	library.gerege.mn	Сурах бичгийн цахим бүртгэлийн систем	
26	plan.igovernment.mn	Төрийн мэдээллийн сүлжээ	
27	Гаалийн алба	CAIS	Гаалийн үндсэн үйл ажиллагааг бүрэн цахимжуулсан цогц систем

28		Able, erp.e-mongolia.mn	Цахим албан хэрэг хөтлөлтийн систем
29	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	urban.gov.mn	Хот байгуулалтын кадастрын цахим систем
30		mcis.gov.mn	Барилгын нэгдсэн мэдээллийн систем
31		MLE.mn	Газрын биржийн цахим систем
32		egazar.gov.mn	Газрын нэгдсэн систем
33		Able, erp.e-mongolia.mn	Цахим албан хэрэг хөтлөлтийн систем
34	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	nas.fcy.gov.mn	Нийгмийн ажил үйлчилгээний нэгдсэн сан
35		Etuslamj.mn	Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээлэл, хууль эрх зүйн болон сэтгэлзүйн зөвлөгөө өгөх боломж бүхий систем
36	Мал эмнэлгийн газар	office.mahis.gov.mn	Динамик оффис- Цахим албан хэрэг хөтлөлтийн систем
37		vetlab.shinjilgee.mn	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори
38		certificate.mahis.gov.mn	Мал эмнэлгийн нэгдсэн систем
39	Нийгмийн даатгалын хэлтэс	app.ndaatgal.mn:811/sd/#/account/login	Сайн дурын даатгалын програм
40		app.ndaatgal.mn/onlineshim	Шимтгэлийн программ
41		emd.gov.mn/rd/search	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт харах
42		Green erp программ	Цахим албан хэрэг хөтлөлтийн систем
43		health.gov.mn	Эрүүл мэндийн даатгалын цахим систем
44		daatguulagch.ndaatgal.mn/#/account/login	Даатгуулагчид зориулсан систем
45		app.ndaatgal.mn/naccount/default.aspx	Нэрийн данс шалгах систем
46			Тэтгэвэр олголтын хяналтын программ
47			Сайн дурын даатгалын програм
48			Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох програм
49	app.ndaatgal.mn/onlineshim	Шимтгэлийн цахим систем	
50		Нөхөн тооцох, нөхөн олгоорт хамрагдсан хүмүүсийн мэдээлийн програм	
51		Эрүүл мэндийн даатгалын орлогын программ, Эрүүл мэндийн даатгалын зардлын программ	
52		Тэтгэмжийн тооцооны программ	
53		Тэтгэврийн тооцооны программ	
54	Онцгой байдлын газар (хэлтэс)	eDoc	Цахим албан хэрэг хөтлөлтийн систем
55			Орон зайн мэдээллийн систем
56			Цахим бүртгэл мэдээллийн систем
57	Орон нутгийн өмчийн газар	Umch.gov.mn	
58	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	Aclous	Нягтлан бодох бүртгэлийн систем

59		www.ich.mongoluv.mn	Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн улсын нэгдсэн бүртгэл
60	Соёл, урлагийн газар	www.rich.mongoluv.mn	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын нэгдсэн бүртгэл
61		khs.moc.gov.mn	Соёлын салбарын нэгдсэн портал
62		plan.igovernment.mn	Төрийн мэдээллийн сүлжээ
63		estandard.gov.mn	Стандартын цахим сан
64	Статистикийн хэлтэс	sudalгаа.1212.mn	Статистикийн судалгаа, мэдээ тайлангийн систем
65		srv.nso.mn	Хэрэглэгчийн бүртгэлийн систем
66		tais.mta.mn	Татварын удирдлагын нэгдсэн систем
67	Татварын хэлтэс	ebarimt.mn	Цахим төлбөрийн баримтын систем
68		itax.mta.mn	Татвар төлөгчийн цахим систем
69		etax.mta.mn	Цахим санхүүгийн тайлангийн систем
70	Улсын бүртгэлийн хэлтэс	edoc.mojha.gov.mn	Цахим албан хэрэг хөтөлтийн систем
71	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	119.40.97.87/currentweather/HMDTS/login.asp	Ус, цаг уур, орчны ажиглалтын мэдээ дамжуулах, хяналт тавих систем
72		ehalamj.mn	Халамжийн нэгдсэн систем
73		ejob.gov.mn	Ажлын байрны систем
74	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	ework.hudulmur-halamj.gov.mn	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний салбарын дотоод үйл ажиллагааны удирдлагын систем
75		pmt2022.hudulmur-halamj.gov.mn	Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааы систем
76		heb2017.hudulmur-halamj.gov.mn	ӨМНС ХЭБ үйлчилгээний цахим систем
77		www.livestock.mofa.gov.mn	Мал аж ахуйн нэгдсэн систем
78	Хүнс, хөдөө аж ахуйн газар	plant.mofa.gov.mn	Тариалан үйлдвэрлэлийн нэгдсэн систем
79		foodsupply.mofa.gov.mn/index	Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох систем
80		ehuulga.mof.gov.mn	И-хуулга
81	Цагдаагийн газар (хэлтэс)	fas.audit.mn	Аудитын систем
82		auth-mojha.opengov.mn	Төсвийн нэгдсэн систем
83		lavlagaa.e-mongolia.mn	Лавлагааны систем
84		1.cd.gps.mn	Зорчих эрхийг хязгаарлах ял хяналтын систем
85	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (хэлтэс)	www.edoc.mojha.gov.mn	Дотоод удирдлагын систем
86			Хоригдогсдын цахим систем
87		Lavlagaa.e-mongolia.mn	Төрийн байгууллагын лавлагааны программ
88			Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл хяналтын систем

89		health.gov.mn	Эрүүл мэндийн даатгалын цахим систем
90		hinfo3	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн систем
91		ehemut.mn	Эх хүүхдийн тандалтын систем
92		EWAR	Халдварт өвчний тандалтын програм
93		FLU	Томуугийн тандалтын систем
94	Эрүүл мэндийн газар	state	Эрүүл мэндийн статистик мэдээний програм
95		vis.health.gov.mn	Вакцинжуулалтын систем
96		Hinfo stata	Статистик, тайлангийн программ
97		Hiep.mn	Эрт илрүүлгийн программ
98		Screening.gov.mn	Хавдрын эрт илрүүлэг
99		Smr.telemedicine.mn	Зүрх судас, чихрийн шижингийн үзлэг
100		FIS.flu.mn	Томуугийн харуулан тандалтын систем
101		Vis.health.gov.mn	Вакцины программ
102		health.gov.mn	Эрүүл мэндийн даатгалын цахим систем
103	Нэгдсэн эмнэлэг	payroll.gov.mn	Цахим татварын систем
104		fis.flu.mn	Томуугийн харуулан тандалтын систем
105		hinfo.mn	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн систем
106		burtgel.mohs.mn	ЭМЯ мэдээллийн цахим систем
107		selection1818.mn	даатгалын гэрээлэлтийн цахим систем
108		heps.hdc.gov.mn	эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн цахим систем
109		esis.edu.mn	Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, сурагч ажилчдын дата мэдээ
110	СӨБ	bi.esis.edu.mn	Байгууллагын болон багшийн үнэлгээний дата боловсруулах
111		stat.eec.mn	Байгууллагын болон багшийн үнэлгээний үр дүн харах
112		library.gerege.mn	Номын сангийн цахим систем
113		esis.edu.mn	Нэгдсэн систем
114	ЕБС	hrm.csc.gov.mn	Төрийн албаны "ХНУМТ" цахим систем
115		auth.itc.gov.mn	Татварын нэгдсэн систем
116		stat.eec.mn	Тайлангийн систем
117	Их Дээд сургууль	ulms.msue.edu.mn	Сургалтын удирдлага, мэдээллийн систем

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. ITU. (2017). The ICT Development Index (IDI): conceptual framework and methodology.
2. Government of South Australia. Digital transformation toolkit.
3. UN. E-Government Survey 2022.
4. World Bank Group. Digital Adoption Index.
5. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”.
6. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.
7. Судалгааны “Digital.sudalгаа.gov.mn” систем.
8. Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан эмхэтгэл.

